МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 20 өдөр Дугаар А/292 Мандалговь

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "е", 29.1.6 "а" заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 48 дугаар тушаалаар батлагдсан "Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Дундговь аймаг дахь "Аэродром орчимд агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: "Мандалговь" нисэх буудлын дарга

Гишүүд:
- Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга
- "Мандалговь" нисэх буудлын нислэгийн мэдээллийн ажилтан
- Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Барилга хот байгуулалт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
- Сайнцагаан сумын Хот тохижуулах газрын дарга
- Сайнцагаан сумын Байгаль, орчны Улсын байцаагч

Нарийн бичгийн дарга: "Мандалговь" нисэх буудлын Аэродромын техникч

2. "Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж хариуцлага, санаачилгатай ажиллахыг "Аэродром орчимд агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл"-д даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн ажлын зохион байгуулалтад хуулийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг салбар зөвлөлийн дарга (Б.Батмөнх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210087